



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл-Нэмэлт санхүүжилт II- ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/76/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн
Ерөнхий захирал Ц.Жигдэн
Утас: 7000-5401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН
ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ-НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ
II-ИЙН ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Б.ОЮУН
ТАНАА

2024.02.29 № 07/585

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл-нэмэлт санхүүжилт II-ийн 2023 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл- нэмэлт санхүүжилт II-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл-нэмэлт санхүүжилт II нь Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан 2018 оны 3713-МОН дугаартай зээлийн гэрээний дагуу 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр хэрэгжиж дууссан.

Тайлант онд төслийн үйл ажиллагаа бүрэн хэрэгжиж, нийт 21.8 сая ам.доллар буюу 59,104,407.3 мянган төгрөгийн зээлийг ашигласнаас барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн худалдан авалтад 88.8 хувийг, төслийн удирдлага болон зөвлөх үйлчилгээнд 5.5 хувийг, бусад зардалд 5.9 хувийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд төслийн нэгжийн гадаад зээлээр хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдлээс 3,961,896.6 мянган төгрөг, гадаад зээлийн эх үүсвэрээс 3,358,740.2 мянган төгрөгийг бүрдүүлж, 7,320,636.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн тайлант жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн 10 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51,518,101,151.46	-
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,037,596,135.38	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,037,596,135.38	-
3121	Төгрөг	1,116,832,784.78	-
31211	Төрийн сангийн харилцах	1,116,832,784.78	-
3122	Гадаад валют	2,920,763,350.60	-
31224	Төрийн сангийн харилцах	2,920,763,350.60	-
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	47,480,505,016.08	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	47,480,505,016.08	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	102,297,043.01	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	102,297,043.01	-
392	Биет хөрөнгө	102,297,043.01	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	181,500,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(79,202,956.99)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	51,620,398,194.47	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,417,757,674.85	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,417,757,674.85	-
413	Өглөг	1,417,757,674.85	-
4136	Бусад өглөг	1,417,757,674.85	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,417,757,674.85	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	50,202,640,519.62	-
51	Засгийн газрын хувь оролцоо	50,202,640,519.62	-
512	Хуримтлагдсан үр дүн	50,202,640,519.62	(20,600,382.08)
51210	Өмнөх үеийн үр дүн	43,823,205,057.33	50,202,640,519.62
51220	Тайлант үеийн үр дүн	6,379,435,462.29	(50,223,240,901.70)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-	20,600,382.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,620,398,194.47	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,962,468,151.99	4,494,721,002.29
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,962,468,151.99	4,494,721,002.29
120	Нийтлэг татварын бус орлого	9,962,468,151.99	4,494,721,002.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,962,468,151.99	4,494,721,002.29
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,571,507,366.58	3,358,740,182.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,390,960,785.41	1,135,980,819.69
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,017,615,269.40	1,009,085,834.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,017,615,269.40	1,009,085,834.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,017,615,269.40	1,009,085,834.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,419,851.42	331,046,651.61
210101	Үндсэн цалин	513,419,851.42	331,046,651.61
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	64,134,000.00	40,934,621.66
210201	Тэтгэврийн даатгал	43,611,120.00	27,710,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,130,720.00	3,306,178.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,104,576.00	2,644,942.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,144.00	661,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,261,440.00	6,612,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,836,500.00	47,147,404.49
210304	Байрны түрээс	85,836,500.00	47,147,404.49
2104	Хангамж, бараа материалын зардал	16,371,471.95	17,165,740.78
210401	Бичиг хэрэг	2,321,986.08	3,366,254.63
210402	Тээвэр, шатахуун	10,691,418.17	11,123,047.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,358,067.70	2,676,438.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,199,799.55	-
210604	Урсгал засвар	18,199,799.55	-
2107	Томилолт, зочны зардал	71,489,900.00	84,547,207.00
210702	Дотоод албан томилолт	71,489,900.00	84,547,207.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,212,950,823.06	310,151,929.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,185,813,226.81	273,466,084.26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,900,000.00	36,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	237,596.25	85,845.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,212,923.42	178,092,279.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,962,923.42	150,921,116.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,250,000.00	27,171,163.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,944,852,882.59	3,485,635,167.65
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	245,257,991.88	73,291,431.66
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	245,257,991.88	73,291,431.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,810,675,412.18	53,782,167,501.01
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	51,585,112,281.79
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	1,810,675,412.18	2,197,055,219.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,565,417,420.30)	(53,708,876,069.35)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,379,435,462.29	(50,223,240,901.70)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,993,933,026.88	2,295,583,778.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,993,933,026.88	2,295,583,778.35
120	Нийтлэг татварын бус орлого	6,993,933,026.88	2,295,583,778.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,993,933,026.88	2,295,583,778.35
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,993,933,026.88	2,295,583,778.35
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,884,093,291.11	964,467,454.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,884,093,291.11	964,467,454.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,884,093,291.11	964,467,454.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,419,851.42	331,046,651.61
210101	Үндсэн цалин	513,419,851.42	331,046,651.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,134,000.00	40,934,621.66
210201	Тэтгэврийн даатгал	43,611,120.00	27,710,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,130,720.00	3,306,178.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,104,576.00	2,644,942.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,144.00	661,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,261,440.00	6,612,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,558,750.00	42,343,064.00
210304	Байрны түрээс	78,558,750.00	42,343,064.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,100,990.27	15,930,850.40
210401	Бичиг хэрэг	2,160,367.90	3,126,181.81
210402	Тээвэр, шатахуун	9,873,636.37	10,360,557.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,066,986.00	2,444,111.51
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,041,169.18	-
210604	Урсгал засвар	17,041,169.18	-
2107	Томилолт, зочны зардал	71,489,900.00	84,547,207.00
210702	Дотоод албан томилолт	71,489,900.00	84,547,207.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,119,513,125.43	298,858,863.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,094,275,529.18	265,773,018.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	25,000,000.00	33,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	237,596.25	85,845.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,835,504.81	150,806,196.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,835,504.81	150,806,196.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,109,839,735.77	1,331,116,323.92
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	7,007,355,953.12	5,442,003,890.96
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	7,007,355,953.12	5,442,003,890.96
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн	245,257,991.88	73,291,431.66
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	245,257,991.88	73,291,431.66
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,762,097,961.24)	(5,368,712,459.30)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,652,258,225.47)	(4,037,596,135.38)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,689,854,360.85	4,037,596,135.38
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,037,596,135.38	-

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	43,823,205,057.33	43,823,205,057.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	43,823,205,057.33	43,823,205,057.33
Тайлант үеийн үр дүн	-	6,379,435,462.29	6,379,435,462.29
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	50,202,640,519.62	50,202,640,519.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	50,202,640,519.62	50,202,640,519.62
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	20,600,382.08	20,600,382.08
Тайлант үеийн үр дүн	-	(50,223,240,901.70)	(50,223,240,901.70)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,357,802,000.00	7,320,636,830.84	37,165,169.16	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	852,402,000.00	815,476,535.63	36,925,464.37	95.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	852,402,000.00	815,476,535.63	36,925,464.37	95.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,070,200.00	331,046,651.61	23,548.39	100.0
210101	Үндсэн цалин	331,070,200.00	331,046,651.61	23,548.39	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,934,700.00	40,934,621.66	78.34	100.0
210201	Тэтгэврийн даатгал	27,710,000.00	27,710,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,306,200.00	3,306,178.70	21.30	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,645,000.00	2,644,942.96	57.04	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	661,200.00	661,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,612,300.00	6,612,300.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,120,000.00	42,343,064.00	6,776,936.00	86.2
210304	Байрны түрээс	49,120,000.00	42,343,064.00	6,776,936.00	86.2
2104	Хангамж, бараа материалын зардал	18,635,100.00	15,930,850.40	2,704,249.60	85.5
210401	Бичиг хэрэг	3,438,000.00	3,126,181.81	311,818.19	90.9
210402	Тээвэр, шатахуун	12,573,100.00	10,360,557.08	2,212,542.92	82.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,624,000.00	2,444,111.51	179,888.49	93.1
2107	Томилолт, зочны зардал	89,592,000.00	84,547,207.00	5,044,793.00	94.4
210702	Дотоод албан томилолт	89,592,000.00	84,547,207.00	5,044,793.00	94.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	320,930,000.00	298,858,863.54	22,071,136.46	93.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	287,844,000.00	265,773,018.29	22,070,981.71	92.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,000,000.00	33,000,000.00	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	86,000.00	85,845.25	154.75	99.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,120,000.00	1,815,277.42	304,722.58	85.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,120,000.00	1,815,277.42	304,722.58	85.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	6,505,400,000.00	6,505,160,295.21	239,704.79	100.0
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	6,505,400,000.00	6,505,160,295.21	239,704.79	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,357,802,000.00	3,358,740,182.60	3,999,061,817.40	45.6
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,357,802,000.00	3,358,740,182.60	3,999,061,817.40	45.6
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		73,291,431.66		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,037,596,135.38		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,781.7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,781.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцоолж бүртгэсэн	1	3,781.7			1	3,781.7	1	3,781.7				
Дүн	1	3,781.7			1	3,781.7	1	3,781.7				

Аудитаар нийт 442.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 442.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлд ногдох алдангийг зээлийн санхүүжилтээс төлсөн.	1	442.3	1	442.3				
Дүн	1	442.3	1	442.3				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.